

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ МӨРӨН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.07.25

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 06/22 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, үр ашгийн байдал, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлт, гадны байгууллага, иргэнтэй хийсэн гэрээ хэлцэл, худалдан авалт, түүний эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, нэгжийн бүтэц орон тоо, цалин хөлсний тооцоолол, албан тушаалын тодорхойлолт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Тус нисэх буудлын ажилчдын ажлын цагийн бүртгэлийг харуулууд нь дэвтэрт гараар бүртгэл хийж, цалин хөлсийг тооцож олгож байгаа нь цалин хөлс алдаатай бодогдож болзошгүй ба ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 6.2-т “Ажилтны ажилд ирсэн, явсан цагийг бүртгэх хяналтын системийг салбар нэгж бүр хэрэгжүүлж мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Тус нисэх буудлын уурын зуухны галч нар зарцуулалтын тайлан гаргаж өгдөггүй зөвхөн нийт дүнгээр бараа материалын шаардах хуудас бичиж зарлагдаж байгаа нь ИНЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3-т заасан Бараа материалын бүртгэлийн горимыг хэрэгжүүлээгүй. Мөн ИНЕГ-ын НБББББ-ийн Бараа материалын бүртгэлийн горим 4.3.2-т ...Шаардах хуудас дэс дугаартай байна... гэж заасан. Гэтэл тус нисэх буудлын бараа материалын баримтыг шалгахад шаардах хуудсыг дугаарлаагүй байна.

Мөрөн нисэх буудлын 2021 оны 08 дугаар сараас 2022 оны 07 дугаар сар хүртэлх хугацааны харилцах дансны баримтыг шалгахад 16 гүйлгээ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.-д заасан шаардлагыг хангаагүй байсныг шалгалтын явцад залруулав.

Хөвсгөл аймаг дахь нисэх буудалд ашиглагдаж буй дизель генераторуудын мотоцагийн заалттай уялдуулж шатахууны тооцоог хийгээгүй, эрчим хүч тасалдсан тохиолдолд дизель генератор ажиллуулахдаа холбогдох байгууллагын тодорхойлолтыг тогтмол аваагүй байна.

Мөрөн нисэх буудалд ашиглагдаж буй автомашинуудын гүйлтийг спидометрийн заалт, мотоцагийн заалттай тулгалгүйгээр шатахууны тооцоог хийсэн.

Тус нисэх буудлын 2022 онд зохион байгуулсан 3 тендер шалгаруулалтыг шалгахад үнэлгээний хорооны гишүүд давхардсан, мөн шалгах өдрийн байдлаар тухайн нисэх



буудалд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гэрчилгээтэй 1 ажилтан ажиллаж байгаа нь худалдан авах ажиллагааг ил тод зохион байгуулах зарчмыг бүрэн хангаж чадахгүй байна

Хөвсгөл аймаг дахь нисэх буудлын 2021 он, 2022 оны эхний хагас жилийн Шилэн дансны мэдээллийг шалгахад бүх мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

Мэдээллийн үнэн зөв байдлыг шалгахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10. дахь заалтыг зөрчиж 6 гүйлгээний шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж хөрөнгө, мөнгө зарцуулсан 5 худалдан авах гэрээг байршуулаагүй байсныг шалгалтын явцад нөхөж 2022 оны 07 дугаар сард мэдээлүүлсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудалд 10 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА